



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/351

Улаанбаатар хот

Үр дүнгийн урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Нэгдсэн эмнэлгийн дарга, захирал нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн ажилтнуудын нэгэн адил улирал тутам үндсэн цалингийн 30-60 хувиар тооцож мөнгөн урамшуулал олгосугай.

2. Удирдлагын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн мөнгөн урамшууллыг улирал тутам олгохыг байгууллагын ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

141201229